



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/133

Хархорин сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2, 6 дугаар багт байрлах 3 нэгж талбарын 1700м² газрыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтанд зааснаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч Амарцогтын Гантулга, Дуламжавын Эрдэнэбат, Дугарын Адъяадорж нарт газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2022 оны А/237 дугаар захирамжийн 5 дугаар, 2013 оны А/221 дугаар захирамжийн 9 дүгээр, 2022 оны А/237 дугаар захирамжийн 60 дугаарт байгаа газар эзэмших эрхийн 0000296723, 000611735, 0000281107 дугаартай гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100265

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 05 -ний өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ЭЗЭМШИЛ ГАЗРАА ШИЛЖҮҮЛЭГЧ, ШИЛЖҮҮЛЭН АВАГЧИЙН НЭРС

Д/д	Газар эзэмшигч иргэн аж ахуйн нэгжийн нэр	Регистрийн дугаар	Шилжүүлэн авалт, аж ахуй нэгж, байгууллагын газрын хэмжээ /м2/	Шилжүүлэн авагчийн нэр	Регистрийн дугаар	Шилжүүлэн авалт, аж ахуй нэгж, байгууллагын газрын хэмжээ /м2/	Хугацаа /жил/	Газрын байршил	Зориулалт	Нэгж талбарын дугаар
1	Гансүх Гандөш	ЙБ86122011	500	Амарцогт Гантулга	ЙР84032471	500	13	Эрдэнэзуугийн гудамж 242	Амины орон сууц	6209007835
2	Цэндээ Бямбасүрэн	ЙР63081934	700	Дуламжав Эрдэнэбат	ЦГ69070717	700	42	Ар хадат худаг	Өвөлжөө	6209006943
3	Очирбат Ганбаатар	ЙС82012010	500	Дугар Адъяадорж	ЙР92013117	500	43	Эрдэнэзуугийн гудамж 240	Амины орон сууц	6209007829
						1700				
						1700				